



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 7 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 7 дугаар сарын 05-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 - 7

- 1. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/*

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 7 дугаар сарын 05-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 57 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Бат-Амгалан, Б.Саранчимэг;

Чөлөөтэй: Ж.Чинбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг, Ч.Ундрэм.

Нэг. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийн түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мэргэжилтэн М.Алтанхорол, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжил, бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга П.Дэлгэрмаа, Төрийн цахим үйлчилгээ, зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Б.Мягмарнаран, “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга М.Баттулга, Боловсрол, шинжлэх ухааны яамны Инновацын газрын захирал Д.Баттогтох, Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл, “Радио, телевиз үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын Захиргаа удирдлагын газрын дарга Ц.Ганзориг, мөн газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Болормаа, “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын Захиргааны албаны менежер Ө.Энхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт П.Болорцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 11 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.6 хувийн ирцтэйгээр 11 цаг 08 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 7 дугаар сарын 05-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 57 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Э.Батшугар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн мэнд хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь бүрэл хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульдаа 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Э.Батшугар 28 дугаар тойрог, Н.Ганибал 12 дугаар тойрог, Т.Доржханд 29 дүгээр тойрог, Ц.Идэрбат 18 дугаар тойрог, Ц.Сэргэлэн 7 дугаар тойрог, Н.Учрал 28 дугаар тойрог.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газар 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ

Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

Х.Булгантуяа сайдын микрофоныг нээе.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны ээлжит чуулганы 7 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан байгаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2022 онд 17.1 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 18.1 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч төлөвлөгдсөн дүнгээс 1.8 их наяд төгрөгөөр буурсан ба сүүлийн 3 жил

дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хороонд харьяалагдах Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын нийт зарлага ба болон цэвэр зээлийн дүн 28.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч урсгал зардалд 23.0 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 5.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улсын төсвөөс 22.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 9.4 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Э.Батшугар: Х.Булгантуяа сайдад баярлалаа.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг танилцуулна. 3 дугаар микрофоныг нээе.

Ц.Наранчимэг: Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн

эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 9 байгууллагын санхүүгийн тайлан дүгнэлт гаргалаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай харьяа 6 байгууллагад өөрчлөлтгүй, 3 байгууллагад хязгаарлалттай санал, дүгнэлтийг өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14.2 тэрбум төгрөгийн 58 зөрчил илэрснээс 0.03 тэрбум төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 12.7 тэрбум төгрөгийн 26 албан шаардлага, 1.4 тэрбум төгрөгийн 23 зөвлөмж, 2 хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй нийт 0.02 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 5 байгууллагын төсвийн захирагч нарт хариуцлага тооцох албан шаардлагыг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн болно.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 4.6 тэрбум төгрөгийн 11 алдаа илэрснийг аудитын явцад 9 алдааг залруулж, 2 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмжийг өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 38.2 тэрбум төгрөгийн

төсөвт өртөгтэй 6.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс шилжин хэрэгжих 27.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5, шинээр хэрэгжих 10.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээ байна.

Төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл 81.6 хувь, санхүүжилтийн гүйцэтгэл 86.3 хувьтай байна.

Тус Байнгын хороо аудитын дүн, дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарлаа хандуулахыг зөвлөж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүйгээс төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг бодитой үнэлэх боломжгүй байна.

Орхигдсон болон олон жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээг богино хугацаанд ашиглалтад оруулах шийдлийг гаргахгүй байгаа нь төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдахаар байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгааны нэг болж байна.

Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах, төсөвт

ачаалал үүсгэж, жил бүрийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байна.

Харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах шаардлагатай байна.

Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтийг тоймлон танилцууллаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Э.Батшугар: Баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүрэлбаатарын Булгантуяа Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийн түр орлон гүйцэтгэгч, Батаагийн Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ядамын Самбууням Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Чойжилсүрэнгийн Тавинжил Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө

оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Бадамдоржийн Билэгдэмбэрэл Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжил, бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Пүрэв-Очирын Дэлгэрмаа Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Пүрэвжавын Батбаатар Төрийн цахим үйлчилгээ, зохицуулалтын газрын дарга, Бавуужавын Мягмарнаран “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга, Мөнхдоржийн Баттулга “Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга, Доржготовын Баттогтох Боловсрол, шинжлэх ухааны яамны Инновацын газрын захирал, Доржгочоогийн Одгэрэл Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал, Цэрэндоржийн Ганзориг “Радио, телевиз үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын Захиргаа удирдлагын газрын дарга, Өлзийбатын Энхтөр “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын Захиргааны албаны менежер, Батаагийн Болормаа “Радио, телевизийн үндэсний сүлжээ” Улсын төсөвт үйлдвэрийн газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, Мэндээгийн Алтанхорол Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлттэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлттэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар танилцуулна.

Хүрэлцэн ирсэн гишүүд болон ажлын хэсэгтээ баярлалаа.

Хуралдаан 11 минут үргэлжилж, 11 цаг 08 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД